

Бүртгэлийн удирдамж

- 2025–2026 оны хичээлийн жилд математикийн олимпиадад оролцох бүх багш, сурагчид www.mmo.mn сайтад өөрсдөө эсвэл сургуулийнхаа бүртгэгч багшаар дамжин бүртгүүлж, хувийн **mmo-ID**-тай болно. Өмнө нь бүртгүүлсэн бол шинэ ID үүсгэх шаардлагагүй.
- Дараах мэдээлэл нь бүртгэлийн үндсэн мэдээлэлд хамаарна:
 - Овог, нэр
 - Регистрийн дугаар
 - И-мэйл хаяг
 - Аймаг/дүүргийн нэр
 - Сургуулийн нэр
 - Анги
 - Оролцох ангилал
 - Хүйс
 - Холбогдох утасны дугаар
- Оролцогч нь нэгээс илүү **mmo-ID**-тай байхыг хориглоно. 2025–2026 оны хичээлийн жилээс эхлэн давхар бүртгэлтэй багш, сурагчдын бүртгэлийг нэгтгэх ажил хийгдэж байна. Регистрийн дугаар болон овог нэр давхацсан тохиолдолд систем бүртгэлийг автоматаар нэгтгэнэ. Бүртгэгч багш бүртгэл нэгтгэхийн тулд дээрх мэдээллийг зөв, ижил байдлаар оруулахад хангалттай.
- Олимпиадад оролцогчдыг бүртгэх ажлыг сургуулийн захирлын тушаалаар батлагдсан олимпиад зохион байгуулах комиссын ахлагч хариуцна. Комиссын ахлагч бүртгэлийг өөрөө эсвэл комиссын бусад гишүүнээр дамжуулан зохион байгуулж болно. Цаашид бүртгэл хариуцсан багшийг **бүртгэгч багш** гэнэ.
- Өмнө нь www.mmo.mn-д бүртгүүлсэн оролцогчид өөрийн **mmo-ID**-гаа бүртгэгч багшид өгнө. Хэрэв бүртгүүлээгүй бол шаардлагатай мэдээллээ бүртгэгч багшид хүргүүлнэ.
- Багш, сурагч бүр өөрийн бүртгэлийн мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцах бөгөөд шаардлагатай бол өөрөө эсвэл сургуулийнхаа бүртгэгч багшаар дамжуулан шинэчилнэ.
- Бүртгэгч багш нь өөрийн сургуулийн 2025–2026 оны хичээлийн жилд ММОХ-ноос зохион байгуулах олимпиадад оролцох бүх багш, сурагчдын бүртгэлийн мэдээллийг www.mmo.mn сайтад оруулж, шинэчилнэ.
- Хэрэв бүртгэгч багш солигдсон бол шинэ бүртгэгч багшийн мэдээлэл болон сургуулийн захирлын тушаалыг хавсарган 10-р сарын 17-ний дотор registration@mmo.mn хаягаар ирүүлнэ.
- Бүртгэлийн үйл явцыг хөнгөвчлөх зорилгоор 2025 оны 10-р сарын 13, 15-ний өдрүүдийн 20:00–21:00 цагийн хооронд хоёр удаа онлайн уулзалт зохион байгуулна. Багш нар өөрт тохирсон өдрийг сонгон оролцоно. Онлайн уулзалтын линкийг www.mmo.mn сайтад нийтэлнэ.
- Бүртгэгч багш оролцогчдын мэдээллийг олимпиад эхлэхээс **дор хаяж 48 цагийн өмнө** www.mmo.mn системд оруулна. Мөн оролцогчдыг системд нэвтрэх, өөрийн мэдээллийг нягтлах боломжийг олгоно. Түүнчлэн, сурагчдын мэдээлэл бүхий excel файлыг татаж авч, хариултыг оруулахад бэлдэнэ.
- Оролцогч бүр www.mmo.mn дахь өөрийн бүртгэл зөв орсон эсэхийг шалгах үүрэгтэй. Хэрэв нэр нь бүртгэлд байхгүй бол олимпиад эхлэхээс **24 цагийн өмнө** сургуулийнхаа бүртгэгч багшид хандаж засуулна.
- Нууц үгээ мартсан хэрэглэгчид https://www.mmo.mn/password_reset/ хуудсаар эсвэл бүртгэгч багшаар дамжуулан шинэчилж болно.
- Бүртгэгч багш өмнөх жилүүдийн оролцогчдыг өмнөх **mmo-ID**-гаар нь бүртгэнэ. Хуучин бүртгэл хадгалагдаж байгаа тул дахин бүртгэх шаардлагагүй. Хэрэв сурагч сургууль сольсон бол түүнийг жагсаалтаас хасна, харин энэ жил оролцохгүй сурагчдыг “бусад” ангилалд шилжүүлнэ.

14. Бүртгэгч багш болон олимпиадын комиссын гишүүд <https://groups.google.com/g/mmo-school-admins> бүлэгт нэгдэж, шаардлагатай мэдээллийг цаг тухайд нь авна. Техникийн асуудал гарах тохиолдолд мэдээлэл тус бүлгээр дамжин хүргэгдэнэ.
15. Бүртгэлтэй холбоотой тусгайлан тусламж авах шаардлагатай бол registration@mmo.mn хаягаар хандана. Энэ үйлчилгээний хураамж 20,000 төгрөг байна.
16. Аймаг, дүүргийн боловсролын газрын бүртгэлээс хоцорсон боловч олимпиадад оролцох хүсэлтэй тохиолдолд эрх бүхий албан тушаалтны томилгооны тогтоол болон mmo-ID (эсвэл бүртгэлийн мэдээллээ) registration@mmo.mn хаягаар ирүүлж бүртгүүлж болно. Энэ тохиолдолд 50,000 төгрөгийн төлбөр төлнө.
17. Төлбөртэй үйлчилгээ авах бол MN10000500 5027785888 дансанд төлбөр хийж баримтаа хавсаргана.